

Манай сэтгүүл Монгол Улсын гадаад харилцааны түүхэнд холбогдолтой онц сонирхолтой, урьд өмнө хэвлэгдэж байгаагүй дотоод, гадаадын архивын баримтуудыг өргөн олон уншигч түмэнд өргөн барьдаг сайхан уламжлалтай билээ. Тэр завсарласны дараа редакцийн зөвлөл **АРХИВЫН БАРИМТ** булангаа дахин нээж байна. Энэ удаа Монгол-Хятадын харилцааны хамгийн ээдрээтэй, зөрчилтэй байсан 1964-65 оны үед хамаарах хэд хэдэн сонирхолтой архивын баримтуудыг толилуулж байна. Тэр үеийн Монголын нам, төрийн тэргүүн Ю.Цэдэнбалтай уулзсан гадаад орнуудын зочид төлөөлөгчид Монгол-Хятад, Зөвлөлт-Хятадын харилцаанд гарсан хүйтрэл, зөрчлийн талаар хэрхэн сонирхон асууж байсан, ямар хариулт авч байсныг энэхүү ярианы тэмдэглэлүүд өгүүлэх болно.

## **Ю.ЦЭДЭНБАЛ ГАДААД УЛС ОРНУУДЫН ТӨЛӨӨЛӨГЧИДТЭЙ УУЛЗАЖ ЯРИЛЦСАН ТЭМДЭГЛЭЛЭЭС**

**МАХН-ын Төв Хорооны 1 дүгээр нарийн бичгийн дарга,  
БНМАУ-ын СнЗ-ийн дарга Ю.Цэдэнбалд Финляндийн элчин  
сайд ноён Ваномо бараалхсан тухай ярианы тэмдэглэл,  
1964.02.17<sup>1</sup>**

*/ Дипломат харилцаа тогтоосны дараа /*

**Цэдэнбал:** Энх тайвныг хамгаалах, энх тайвнаар зэрэгцэн орших зарчмыг биелүүлэх явдал бол бидний гол зорилт байгаа юм.

**Ваномо:** Тийм ээ, энх тайвны төлөө нийтийн тэмцэлд хувь нэмрээ оруулах явдал бол бидний гол зорилт байгаа юм. Манай 2 улс мэтийн бага улсуудын философи ийм л байх ёстой.

**Цэдэнбал:** Хятадуудтай, жишээлэхэд: Энх тайвнаар зэрэгцэн орших асуудлаар санал зөрж байна. Энэ зарчим бол ЗХУ, социалист бусад орнуудын гадаад бодлогын үндсэн зарчим байгаа юм. Орчин үеийн зэвсгийн байдлыг харгалзан үзэхэд одоо дайн гарвал нийтэд онц их аюул хөнөөлтэй болох юм. Хятад нөхөд энэ талаар дэндүү дайнч байр суурь эзэлж байна. Тайваний арал бол Хятадын газар нутгийн хэсэг бөгөөд Америкчууд түүнийг эзэлж байгаа болохоор хятад нөхдийн санаа сэтгэл энэ талаар ямар байгааг бид ойлгож байна. Гэвч нэг арлаас болж дайн дэгдээх хэрэггүй юм. Энэ нь хятадууд, америкчуудад аль алинд нь ашиггүй юм. Энэ арал аажимдаа чөлөөлөгдөж эх нутагтайгаа нэгдэх нь эргэлзээгүй хэрэг.

**Ваномо:** Тайваний тухай асуудал байна. Мөн нөгөө талаар хятадууд атомын бөмбөгтэй болох гэсэн бодол санаагаа энэ маргааны ар талд нууж байна гэж ярилцдаг. Энэ үнэн болов уу?

**Цэдэнбал:** Хятадын ард түмний амьдрал одоогоор ядуу байна. Атомын бөмбөг үйлдвэрлэх гэж өчнөөн их хөрөнгө зарцуулах шаардлага алга. ЗХУ-д байгаа цөмийн зэвсэг социалист бүх орныг хамгаалахад хүрэлцээтэй байна. Гэтэл хятадууд эрх хүүхэд шиг айлын хүүхэд ийм маягийн гутал, хувцас өмссөн байна, би бас тийм хувцас заавал өмсөнө гэж аашилж байдаг шиг загнаж байна. Одоо үеийн зэвсэг техникийг урьд аль ч үеийнхтэй зэрэгцүүлэхийн аргагүй их аюултай зэвсэг юм. Ийм нөхцөлд зэвсэглэлийн хойноос хөөцөлдөх нь үлэмж аюултай хэрэг. Хятадууд атомын зэвсэгтэй болбол, баруун Герман бас атомын зэвсэгтэй болох гэж хөөцөлдөнө, хөөцөлдөж ч байна.

**Ваномо:** Хятадууд өөрийн атомын зэвсэгтэй болсон хойно бас ийм бодлого явуулбал бүр ч аюултай болох юм.

**Цэдэнбал:** Хэрэгтэй бол зуун жил ч оролдсоор байгаад цөмийн зэвсэгтэй болно гэж хятад нөхөд хэлж байна. Энэ бол бодит байдалтай тохирохгүй бодлого юм. Хятад улс дэлхий дээр хамгийн олон хүн амтай нь үнэн. Үүнээс үндэслэн хятадууд үндэсний дээрэнгүй үзэлд хүрч байна.

**Ваномо:** Үзэл суртлын энэ маргаан Монгол-Хятад 2 улсын харилцаанд яаж нөлөөлж байна вэ?

**Цэдэнбал:** Чан Кайшигийн үеийн Хятадын газрын зурагт Монгол улсыг Хятадын хэсэг болгон зурсан байсан. Энэ ч яахав. Ойлгомжтой хэрэг. Гэтэл БНХАУ энэ хуучин газрын зургийг 1962 он хүртэл баримталж, тархаан дэлгэрүүлж байсныг бид ойлгохгүй байна. Тэр зургийг баримтлан сургуулийн сурагчдад хичээл заадаг байсан. ...2 улсын хилийн шугамыг газар дээр нь тодорхойлон тогтоож дуусгаад байгаа. Одоо зураг дээр ажиллаж байна. Энэ ажил нилээд хугацаа авах байх.

**Ваномо:** Синьзяны районд Зөвлөлт, Хятадын хооронд хилийн мөргөлдөөн 5000 орчим удаа болсон гэж хэвлэлд бичсэн байна. Ийм явдал танайд тохиолдож байсан уу?

**Цэдэнбал:** 2 улсын хилийн хэлэлцээр хийхийн өмнө ийм явдал гарч байсан. Энэ нь ялангуяа 1958-1962 оны дунд үе хүртэл нилээд гарч байсан. Одоо ийм маргалдаан гарахгүй байна. Тус 2 улсын хилийн хэлцээрийн үр дүнд шугамын урт нь 4500 км, энэ шугамын дагуу 17 мянган хавтгай дөрвөлжин км хэмжээтэй газар маргаантай байсан юм. 12000 нь манайд, 5000 орчим нь хятадын нутагт хамаарагдан орсон юм.

**Ваномо:** Хэрэв та зөвшөөрвөл 1 зүйлийг асууя. Энэ маргааны улмаас олон улсын коммунист хөдөлгөөний дотор хятадын талыг барьсан фракци бүлэг гарч байна. Танай намын дотор ийм зөрчил бий юу? Зарим оронд ийм фракц бүлэг гарч амжилт олсон явдал ч бий шүү дээ.

**Цэдэнбал:** Манай намын нэгдэл бат байна. Хятад нөхөд биднийг тайван байлгахгүй нь лавтай. Бидний дотор үндэсний үзлийг шатаах гэж оролдож байна. Монголчууд эрт үед Оросыг эзэлж байсан гэдгийг үндэс болгон аваад үндэсний үзлийг дэгдээж монгол, оросын ард түмнийг хооронд нь дайсагналцуулах, ЗХУ-аас биднийг салгах гэж оролдож байна. Бид ийм оролдлоготой шийдвэртэй тэмцэж байна.

**Цэдэнбал** цааш нь ярихдаа- Ажлын хүчний тухай асуудал байна. Монгол-Хятад 2 улсын хэлэлцээр ёсоор манайд 12000 хятад ажилчид ажиллах ёстой. Үүнээс 5000 гаруй нь нутаг буцсан. Жирийн хятад ажилчид манайд сайн ажиллаж байсан юм. Гэтэл үзэл суртлын зөрчилдөөний үед хятадууд зориуд дээрээс нь зохион байгуулж ажил хаяулах зэрэг элдэв ажил хийж байна. Энэ нь бидэнд ихээхэн хохирол учруулж байна. Энэ тухай н.Жоу Эньлайд хэлэхэд “манай улс ажил хаях асуудлыг дотооддоо зөвшөөрдөг юм” гэж хариулсан.

**Цэдэнбал...**-Хятадад 1,8 сая монголчууд бий. Хятадууд одоо эдгээр монголчуудыг уусгах ажил зориуд зохион байгуулж байна. Монгол залуучуудыг Кантон, Шанхай зэргийн өмнөх нутагт албаар аваачиж нутаглуулж байна. Хятадын удирдагчид үндэстний цөөнхийн талаар бол иймэрхүү буруу бодлого явуулж байна.

**1965.12.20-нд Японы тусгай сурвалжлагч Ито БНМАУ-ын нийслэл Улаанбаатар хотын Засгийн газрын давхар байшинд Ерөнхий сайдын албан тасалгаанд Монгол улсын Ерөнхий сайд бөгөөд МАХН-ын Төв хорооны 1-р нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбалтай хийсэн тусгай үулзалтын тэмдэглэл<sup>2</sup>**

*Тэд төлөвлөгөөт Ш – 5 жилийн суулчийн энэ жилд улс ардын аж ахуй, эдийн засгийн хөгжлийн тухай асуудал, дотоод гадаадын бодлогын талаар Зөвлөлтийн дэвшүүлж буй бодлого, бас Япон-Монголын хэвийн харьцааны тухай асуудлаар ярилцсанаас гадна анхаарал татах нэг зүйл бол Монгол-Хятадын харилцаанд төрийн тусгаар тогтнолыг хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох тухай, Хятад-Зөвлөлтийн маргаан, эдийн засгийн тусламж, Өвөр Монголын өөртөө засах районы тухай асуудал, Монгол-Хятадын хоорондох асуудал зэргийг ярилцлаа.*

**Ито** /Японы тусгай сурвалжлагч/ - 1965.12.18-нд хуралдсан АИХ-ын чуулганаар ямар асуудал шийдвэрлэв?

**Ю.Цэдэнбал** /МАХН-ын Төв хорооны ерөнхий нарийн бичгийн дарга/: - ХАА-г хөгжүүлэх, малын бэлчээрийг нэмэгдүүлэх, мах, сүү,

ноос, шир, улсад бэлтгэх үнийг нэмсэн нь малчдын сонирхолыг дээшлүүлж болохыг авч хэлэлцлээ.

**Ито:** Эдийн засгийн бүтээн байгуулалтанд танай улс гадаадаас тусламж авч байна уу? Одоо Хятадын баримталж байгаа өөрийн хүчинд тулгуурлах гэсэн бодлоготой үндсээрээ өөр үү?

**Ю.Цэдэнбал:** Тусламж авах гэдэг өөрийн хүчийг гаргахгүйгээр бусдын хүчинд тулгуурлах гэсэн хэрэг биш юм. Өөрийн хүчийг дээд хэмжээгээр гаргаж, тэгээд хүрэлцэхгүй бол ах дүү орны тусламжийг авч, бүтээн байгуулалтдаа хэрэгжүүлэх юм. Жишээ нь: Би өөрөө 70 кг юм өргөх чадалтай, гэтэл хэрэгцээ 120 кг-ийг өргөх шаардлагатай байдаг. Тэгвэл бид 50 кг-ыг бусдын тусламжаар өргөх болно. Хятад улс ах дүү орны тусламж авч бүтээн байгуулалтаа хийсэнсэн бол одоогийнхоос түргэн хөгжих байсан байх.

**Ито:** Тэгвэл Монгол одоо хэдэн кг-ийг өргөх чадалтай байна, мөн хэдийг бусдаар..?

**Цэдэнбал:** Одоо 70 кг өргөх чадалтай байна. Гэтэл 100 кг өргөх шаардлагатай байдаг. Одоо улсын төсвийн 3/1 %-ийг гадаадаас авсан тусламжаар бүрдүүлдэг.

**Ито:** Хятад, Зөвлөлтийн зөрчилдөөний талаар та юу гэж үзэж байгаагаа ярина уу?

**Цэдэнбал:** Хятад, Зөвлөлтийн зөрөлдөөн бол хятад, зөвлөлтийн хоорондын зөрөлдөөний асуудал биш ээ. Хятадын удирдлага бүх дэлхийн коммунистуудын хооронд болж байгаа юм.

**Ито:** 1965.11.11-нд Хятадын Жэньминь жибао сонинд бичсэн зүйлийн эсрэг Правда сонинд нийтлэл гарсан. Ер нь хятад, зөвлөлтийн сөргөлдөөнийг нийтэд задруулахгүй гэсэн явдал байна уу?

**Цэдэнбал:** Энэ талаар III сард 19 орны коммунистууд нийтэд дэлгэрүүлэхгүй гэж шийдсэн.

**Ито:** Хятад, Зөвлөлтийн сөргөлдөөн ба эдийн засгийн бүтээн байгуулалтын талаар МАХН дотор зөрөлдөөн гарсан гэж дуулсан үнэн үү?

**Цэдэнбал:** Одоо бол байхгүй. Урьд нь 1-2 хүн дээр гарч байсан. /1964 оны НТХ-ны бүгд хурал дээр Цэдэнбалын бодлогын талаар гарсан эсэргүүцэлтэй холбогдуулан энэ асуудлыг асуусан бололтой. Ж.Т/

**Ито:** Монгол улс Зөвлөлт, Хятадтай ямар харилцаатай байна?

**Цэдэнбал:** Монгол-Зөвлөлтийн харилцаа бол тэгш, харилцан бие биеэ хүндэтгэсэн, харилцан туслалцах зарчмын үндсэн дээр Зөвлөлтийн тусламжаар Монгол хөрөнгөтний бус хөгжлийн замаар социалист бүтээн байгуулалтыг амжилттай байгуулж байна. Хятад-Монголын харилцааны хувьд харилцан тэгш эрх, бие биеийн дотоод

хэрэгт үл оролдох, төрийнхөө тусгаар тогтнолыг харилцан хүндэтгэх зарчмыг баримталж байна.

**1964.02.15 Индонезийн элчин сайд ноён Сукарни,  
СнЗ-ийн дарга Ю.Цэдэнбалд бараалхсан тухай  
уулзалтгарианы тэмдэглэл<sup>3</sup>**

**Сукарни:** Хятад, Зөвлөлтийн маргааныг зохицуулахын тулд манай Ерөнхийлөгчөөс ноён Хрушев, Мао Зэдун нарт захидал бичсэн. Энэ маргааныг хэлэлцээрийн замаар түргэн шийдэх нь Ази, Африкийн орны эв санааны нэгдэл, империализм, колоничлолын эсрэг тэдний тэмцэлд тус болох юм гэж санаж байна. Энэ маргааныг шийдвэрлэх талаар танд ямар санал байна вэ?

**Цэдэнбал:** Энэ зөрчилдөөн бол зөвхөн Хятад-Зөвлөлтийн хоорондын зөрчилдөөн биш, хятадын удирдагчид бүх коммунист хөдөлгөөн болон ихэнх социалист оронтой зөрөөнтэй байгаа юм. Энэ зөрчилдөөн энх тайвныг хамгаалах, империализмыг эсэргүүцэхэд саад болж байна. ЗХУ, социалист ихэнх улсууд коммунист намуудын дийлэнх нь энэ маргааныг арилгахын тулд их хүч тавьж байна. Харин хятад нөхдүүд үүнийг хүлээж авалгүй улам хурцатгах тал руу ажиллаж байна. Ил маргааныг Хятадын сонин хэвлэлд өдөр бүр шахам бичиж, радиогоор нэвтрүүлж байгааг та сайн мэдэж байгаа байх.

**Сукарни:** Хятадууд ийм ажил зохиож байна. Гол санаа зорилго нь юунд оршиж байна гэж та үзэж байна вэ?

**Цэдэнбал:** Хятадууд олон улсын зарим чухал асуудлыг буруу ойлгож байна. Жишээ нь: Энх тайвнаар зэрэгцэн орших зарчим байна. Манай социалист орнуудын гадаад бодлогын үндэс бол энх тайвнаар зэрэгцэн орших зарчим байгаа юм. Энэ асуудалд хятадын нөхдүүд социалист ихэнх улсуудынхаас өөрөөр хандаж байна. Хятадын ганц онол, уриалга нь биш, мөн тэдний хийж байгаа жинхэнэ үйл ажиллагаа нь зэрэгцэн орших зарчмын эсрэг, байдлыг хурцатгахад чиглэгдэж байгаа нь харамсалтай юм.

**Сукарни:** Ойрын ирээдүйд энэ асуудлыг шийдвэрлэж болох болов уу?

**Цэдэнбал:** Ихэнх социалист орнууд болон коммунист намууд энэ асуудлыг нааштай шийдвэрлэхийг чармайж байна.

**Сукарни:** Хятад улсыг НҮБ-д оруулбал түүний бодлогод нөлөөлж болох юм. Одоо Хятадтай ярилцахад их хэцүү байна. Энэ ч учраас Бандунгийн II бага хурал хийж, тэдэнтэй тойруу замаар нөлөөлөх нь зүйтэй гэж үзэж байна... Хятад, Монголын харилцаа 50% хорогдсон нь хэний буруу вэ?

**Цэдэнбал:** Хятадын талаас болсон.

**Сукарни:** Хятадууд танай талаас болсон гэх юм.

**Цэдэнбал:** 1964 оныг 1963 онтой харьцуулахад транзит тээвэр 39% буурах болж байна. Төмөр замын дөнгөж 20% ашиглагдаж байна.

**Сукарни:** Үзэл суртлын зөрөлдөөнийг улсын харилцаанаас гадуур байлгаж болдоггүй юм уу?

**Цэдэнбал:** Бид энэ асуудлыг улсын харилцаанд дэлгэрүүлэх дургүй байна. Гэтэл хятад нөхдүүд асуудлыг хурцатгах чиглэл барьж байна. Та хятадад суудаг элчин сайдын хувьд энэ асуудлыг биднээс илүү мэдэж байгаа биз дээ.

**Сукарни:** Тусгаар тогтнолоо олохын төлөө тэмцэж байгаа улсуудад Зөвлөлт улс туслахгүй байна гэж хятадууд ярьж байна.

**Цэдэнбал:** 1962 оны 12-р сард хилийн гэрээ байгуулахаар манай төлөөлөгчид Бээжинд очихдоо н.Жоу Энъяйд саналаа тодорхой тавьсан. Хятадууд манай саналыг хүлээж авахгүй байна. Бид тэдний баримталж буй шугамыг буруу гэж шууд хэлсэн. Хятад, Зөвлөлт улсын бодлогыг урвуулж байна. Зөвлөлт улсыг бусдад туслахгүй, харин бусдыг эрхшээлдээ оруулахыг оролдож байна гэж үздэг. Энэ бол буруу юм. Бид бол Зөвлөлт улстай 40 гаруй жил нэгэн лагерьт амьдран хамтран ажиллаж байна. Энэ талаар би ганц жишээ хэлье. Бид үр тариа болон гурилыг Зөвлөлт улсаас авч байсан. Одоо бид Зөвлөлт улсын санхүү-техникийн тусламжтайгаар атар газар эзэмшиж, үр тариа ба гурилын хэрэгцээгээ өөрсдөө хангах болов. Сүүлийн 4 жилийн дотор ийм өөрчлөлт гарсан юм. Одоо бид илүү гарсан үр тариагаа социалист бусад улсууд, түүний дотор Зөвлөлт улсад худалдаж байна. Хэрэв Зөвлөлт улс биднийг эрхшээлдээ байлгах гэсэн бол бидэнд санхүү-техникийн тусалцаа үзүүлэхгүй, атар газар эзэмшихэд туслахгүй байсан юм. Энэ бол зөвхөн нэг жишээ бөгөөд ийм олон жишээ хэлж болох байна. ЗХУ-аас бусад орнуудад үзүүлж байгаа тусламж бол чин сэтгэлийн тусламж юм.

*Хэвлэлд бэлтгэсэн Ж.Төгсжаргал  
/Ph.Докторант/*

### ЭХ СУРВАЛЖ

1. МАХН-ын Төв архив, Ф4, Т28, хн-182, хуудас 96-104
2. МАХН-ын Төв архив, Ф4, Т-28, хн-309, хуудас 140-145, “Монголын замнах зам”
3. МАХН-ын Төв архив, Ф4, Т-28, ХН-182, хуудас 85-95